



**НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 31 өдөр

Дугаар Б/360

Улаанбаатар хот

Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол, Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн ёс зүйн зөвлөлийн гишүүдийг өөрчлөх хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дүүргийн Ёс зүйн зөвлөлийн гишүүн С.Туулмаа, М.Сампилноров нар нь өөр ажилд томилогдон ажиллах болсонтой холбогдуулан ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаатайгаар шинэчлэн байгуулсугай.

Ёс зүйн зөвлөлийн дарга:	А.Батсайхан	Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт шинжилгээний хэлтсийн дарга
Гишүүд:	Б.Мөнгөншагай	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	Р.Ганбаяр	42 дугаар хорооны нийгмийн ажилтан
	М.Оюунцэцэг	Аж ахуйн тасгийн тохижилт, үйлчилгээ хариуцсан ажилтан
Нарийн бичгийн дарга:	Б.Даваабаяр	Төрийн захиргааны хэлтсийн мэргэжилтэн

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг ёс зүйн зөвлөл /А.Батсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ТӨМӨРБААТАР

1180201916